

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТАЙЛАН ХҮЛЭЭЖ АВАХ СИСТЕМИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

ТӨСЛИЙН НЭР: Санхүүгийн Зохицуулах Хороо - Мөнгөн Зээлийн Үйл Ажиллагаа Эрхлэгч этгээдийн тайлан хүлээж авах систем

БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРАМ:

- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, түүнд хяналт тавих журам
- Кибер аюулгүй байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт;

ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ:

Санхүүгийн зохицуулах хороо мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг тайлан хүлээж авах, мэдээллийн сан үүсгэх.

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү ажил гүйцэтгэх үйлчилгээний зорилго нь 1000 орчим мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд, түүний салбар нэгжээс зээлдэгчийн, зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл, барьцаа хөрөнгийн гэрэл зураг, серийн дугаар гэх зэрэг шаардлагатай мэдээллийг цуглуулах, өгөгдлийн сан үүсгэх, шаардлагатай тайлан, мэдээ боловсруулах, файл хэлбэрээр татан авах, цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн цахим бүртгэлийн сангаас шүүх, тулган харах боломжтой, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 82 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх журам”-ын хавсралтаар баталсан маягтын дагуу тайлан хүлээн авах, тайлан нэгтгэх, тайлангийн загварыг дахин өөрчлөх, шинээр зохион байгуулах, нэмэлт тайлангийн загвар үүсгэх модуль бүхий санхүүгийн програм бүтээхэд оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Ажлын даалгавар боловсруулсны дагуу дээр дурдсан ажлын зорилгод үндэслэн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хангахуйц байдлаар нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө буюу ажлын даалгаврыг боловсруулна. Ингэхдээ тухайн системийн ажиллах зураглалыг гаргаж, front-end буюу программ ашиглах этгээд талаас, back-end буюу програмын сервер талаас харагдах байдал, бүтэц, мэдээллийг, хадгалах талаар ажлын даалгаварт дэлгэрэнгүй тусгаж, тухайн програм ажиллах зураглал, E-Mongolia, Хур, Дан, Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн цахим бүртгэлийн сан зэрэг програмуудтай мэдээлэл солилцох API интеграци, програмын тасралтгүй, найдвартай, үнэн зөв мэдээлэл боловсруулах байдлыг хангах.

3. ХИЙГДЭХ АЖЛУУД

ДААЛГАВАР 1:

Мөнгөн зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн зээлийн бүртгэл хийх, барьцаа хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн сантай тулгах, тайлан бэлтгэх илгээх ажилбарыг цахимжуулах зорилгын дагуу эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн дараах шаардлагын дагуу системийг хөгжүүлнэ.

Үүнд:

- Системийн нэгдсэн нэг платформ дээр хийж дэд системүүдийг модуль хэлбэрээр зохион байгуулна.
- Цагдаагийн ерөнхий газрын бүртгэл мэдээллийн системтэй холболт хийнэ.
- Санхүүгийн зохицуулах хороо, Мөнгөн зээлийн үйлчилгээ эрхлэгч, Цагдаагийн ерөнхий газрын хандалттай 3 төрлийн хэрэг
- Гар утас, таблет зэрэг бусад төхөөрөмж дээрээс нэвтрэх үед харагдац эвдрэхгүй байхаар уян хатан дизайн /responsive design/ бэлтгэх.
- Кибер аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх.

ДААЛГАВАР 2:


Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийн бүртгэл хийх модуль хөгжүүлэх.

- Хэрэглэгчийн мэдээлэл
- Зээлдэгчийн мэдээлэл
- Зээлийг мэдээлэл - Зээлийн гэрээ
- Зээлийн мэдээлэл - Батлан даалтын гэрээ
- Зээлийн мэдээлэл - Барьцаа хөрөнгийн гэрээ

ДААЛГАВАР 3:

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч зээлийн барьцаа бүртгэлийн модуль хөгжүүлэх, дараах шаардлагатай мэдээллийн сангуудаас мэдээллийг татах илгээх дундын сан бий болгох.

- Цагдаагийн ерөнхий газрын алдагдсан эд хөрөнгийн мэдээллийн сантай холбогдох;
- Цагдаагийн ерөнхий газрын алдагдсан эд хөрөнгийн мэдээллийн сангаас мэдээлэл шүүж харах;
- Цагдаагийн ерөнхий газрын алдагдсан эд хөрөнгийн мэдээллийн сангаас мэдээлэл шүүж тулгалт хийх;
- Цагдаагийн ерөнхий газрын алдагдсан эд хөрөнгийн мэдээллийн сангаас мэдээлэл шүүж, хулгайлагдсан эд зүйлс илэрсэн тохиолдолд ЦЕГ-т мэдэгдэх




Зураг 1. Зээлийн барьцаа бүртгэх процесс диаграм

ДААЛГАВАР 4: Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах тайлан мэдээг санхүүгийн зохицуулах хороонд илгээх модуль хөгжүүлэх.

- Зээлийн бүртгэлийн дэвтэр.
- Зээлийн нэгдсэн тайлан.
- Санхүүгийн тайлан.
- Үүрэг гүйцэтгэсэн зээлийн мэдээ.

ДААЛГАВАР 5: Санхүүгийн зохицуулах хороо - мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тайлан хүлээж авах системд дараах 3 төрлийн нэвтрэх эрх тохируулах боломжтой байна .

- Санхүүгийн зохицуулах хороо.
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид.



Зураг 2. Тайлан мэдээ илгээх процесс диаграм

ДААЛГАВАР 6: Байгууллага, албан хаагчдад сургалт, нэвтрүүлэлт хийх. Үүнд:

- Бүх түвшний хэрэглэгчдэд сургалт зохион байгуулах
- Системийн ашиглалтын зааварчилгаа бүхий цахим гарын авлага бэлтгэх
- Системийг цаашид хариуцан ажиллах инженер, техникийн ажилчдад сургалт зохион байгуулах
- Нэвтрүүлэлтийн үйл явцыг удирдан зохион байгуулах
- Нэвтрүүлэлтийн үйл явц хэрэглэгчийн асуудлыг шийдвэрлэх, холбогдох мэдээллээр бүрэн хангаж ажиллах

4. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТАЙЛАН ХҮЛЭЭЖ АВАХ СИСТЕМ

№	Системийн бүтэц	Хамаарах мэдээллүүд
1	Хэрэглэгчийн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - Нэр - Иргэн бол иргэний нэр, Хуулийн этгээд бол байгууллагын нэр - Хэрэглэгчийн төрөл <ol style="list-style-type: none"> 1. Байгууллага бол "Барьцаалан зээлдүүлэх газар", 2. Иргэн бол "Зээлийн үйлчилгээ" - Овог - Системд нэвтэрсэн хэрэглэгчийн мэдээлэл - Нэр - Системд нэвтэрсэн хэрэглэгчийн мэдээлэл - Регистрийн дугаар - Системд нэвтэрсэн хэрэглэгчийн мэдээлэл - Салбарын нэр - Үйл ажиллагаа явуулж байгаа салбар - Хаяг - Үйл ажиллагаа явуулж байгаа хаяг - Төрөл - 1. МЗҮАЭ Иргэн <ol style="list-style-type: none"> 2. МЗҮАЭ Хуулийн этгээд 3. Цагдаагийн ерөнхий газрын ажилтан 4. Санхүүгийн Зохицуулах Хорооны ажилтан /Системийн админ/ - Хувийн дугаар - СЗХ болон аймаг дүүргийн засаг даргаас оноосон - Бүртгэлийн төлөв - 1. Хэвийн <ol style="list-style-type: none"> 2. Шалгагдаж буй 3. Зөрчилтэй 4. Үйл ажиллагаа зогсоосон - Утасны дугаар - Гар утасны дугаар - Ажлын дугаар - Ажлын дугаар

2	Зээлдэгчийн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - Ургийн овог - Овог - Нэр - Регистрийн дугаар - Хүйс - Төрсөн огноо - Гэрийн хаяг - Иргэний үнэмлэхийн хаяг - Оршин суугаа хаяг - Утасны дугаар - Холбоо барих хүн - Батлан даагч эсэх
---	----------------------	--

3	Зээлийн мэдээлэл (зээлийн гэрээ)	<ul style="list-style-type: none"> - МЗҮАЭ этгээдийн мэдээлэл - Зээлдэгчийн мэдээлэл - Зээлийн гэрээний дугаар - Огноо - Гэрээний хугацаа - Зээлийн хугацаа - Зээлийн хүүгийн хэмжээ - Хүү бодох аргачлал - Зээлийн эргэн төлөлтийн хуваарь - Дансны дугаар - Барьцаа батлан даалттай эсэх - Хугацаанаас өмнө эргэн төлөлт хийх нөхцөл - Нэмэгдүүлсэн хүүтэй эсэх - Шаардлагатай бусад нөхцөл
---	----------------------------------	---

4	Зээлийн мэдээлэл (батлан даалтын гэрээ)	<ul style="list-style-type: none"> - МЗҮАЭ этгээдийн мэдээлэл - Зээлдэгчийн мэдээлэл - Батлан даагчийн мэдээлэл - Огноо - Гэрээний хугацаа - Зээлийн хэмжээ - Зээлийн хүүгийн хэмжээ
5	Зээлийн мэдээлэл (барьцаа хөрөнгийн гэрээ)	<ul style="list-style-type: none"> - Барьцаа хөрөнгийн үнэлгээ - Барьцаа хөрөнгийн зураг - Барьцаа хөрөнгийн шинж тэмдэг - Барьцаа хөрөнгийн төрөл - Барьцаа хөрөнгийн бренд - Барьцаа хөрөнгийн товч утга - Барьцаа хөрөнгийн тайлбар - Барьцаа хөрөнгийн эзэмшигч болон бусад мэдээлэл/байршил/
6	ЦЕГ алдагдсан эд зүйлсийн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - Нэршил - Э/С зарлалтын дугаар - Эрүүгийн хэргийн ангилал - Төрөл – 1. Цахилгаан бараа <ul style="list-style-type: none"> 2. Үнэт эдлэл 3. Бэлэн мөнгө, карт 4. Тавилга 5. Хүнсний бүтээгдхүүн 6. Нийтийн эзэмшлийн хөрөнгө 7. Тээврийн хэрэгсэлийн эд анги 8. Хувцас, хэрэглэл 9. Телевиз 10. Компьютер 11. Гар утас 12. Эд өлгийн зүйл 13. Хивс, дрож, дэвсгэр - Сери, дугаар - Үйлдвэрлэсэн улс - Өнгө - Үнэлгээ - Нэр - Бренд - Тоо ширхэг - Үйлдвэрлэсэн компани - Хэмжээ - Тухайн эд зүйлсийн үзүүлэлт - Онцлог, содон шинж - Зураг - Тайлбар

7	Тайлан мэдээ цэс	<p>“Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам”- ын дагуу хавсралт 1, хавсралт 2, хавсралт 3, хавсралт 4 – ийн дагуу</p> <ul style="list-style-type: none"> - Бүртгэлийн дагуу - Зээлийн нэгдсэн тайлан - Санхүүгийн тайлан - Үүрэг гүйцэтгэсэн зээлийн мэдээ <p>Энэхүү 4 тайланг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу МЗҮАЭЭТгээд нь бөглөж илгээх бөгөөд өмнөх 2-5 жилийн мэдээллийг харьцуулж, шүүх боломжтой байхаар хөгжүүлэх.</p>
8	Системийн дотоод хяналт	<ul style="list-style-type: none"> - Хэрэглэгчдэд ойлгомжтой энгийн алдааны мэдэгдэлтэй байх. Гарч болох энгийн алдаа бүрийг тооцон барьсан байх; - Хэрэглэгчийн нэвтрэлтийн болон үйлдлийн түүхчилсэн лог мэдээллийг бүртгэх, шүүж харах боломжтой байх;
9	Хэрэглэгчийн эрхийн тохиргоо	<ul style="list-style-type: none"> - Хандах эрхийн түвшинг доорх 4 төрлийн тогтоох <ol style="list-style-type: none"> 1. МЗҮАЭ Иргэн 2. МЗҮАЭ Хуулийн этгээд 3. Цагдаагийн ерөнхий газрын ажилтан 4. Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан /админ/
11	Тусламж цэс	<ul style="list-style-type: none"> - Системийн гарын авлага - Холбогдох эрхзүйн баримт бичгүүдийг байршуулах

5. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

№	Шаардлагын нэр	Шаардлагууд
1	Админ эрхийн түвшинтэй	<ul style="list-style-type: none">- Нэвтрэх эрхийн хязгааргүйгээр системд нэвтрэн өгөгдөл засах, харах, оруулах, хянах зэргийг хийдэг байх
2	Хайлтын системтэй байх	<ul style="list-style-type: none">- Төрөл бүрийн дугаар, он сар, байрлал, төлөв байдал гэх мэт өгөгдлүүдийг хайх уян хатан хайлтын системээр хангах- Уян хатан хайлт хийх боломжтой байх (утгын хязгаар, огноо, текст, төлөв гэх мэт)
3	Тайлан	<ul style="list-style-type: none">- Бүх ангиллаар мэдээллийг дурын цаг хугацаагаар гаргадаг байх- Бүх төрлийн болон захиалагчийн өгсөн батлагдсан тайлангийн маягтаар тайлан мэдээ, тоон үзүүлэлт, график гаргах ба xlsx өргөтгөлөөр хадгалах, хэвлэх боломжтой байх.- Тайлан, мэдээг хэрэглэгчийн тусгайлсан шаардлагын дагуу зохиох, өөрчлөх боломжтой байх
5	Нууцлал, аюулгүй байдал	<ul style="list-style-type: none">- Сүлжээний урсгалыг “SSL/TLS” шифрлэлтийн технологи ашиглан хамгаалах тухай хяналтыг оруулах.- Системийг хөгжүүлэхдээ “Хүчирхэг нууц үгийн бодлого”-ыг хэрэгжүүлэх. Нууц үгийн урт, бүрдэл, солих хугацаа зэргийг уг бодлогод нийцүүлэн хөгжүүлэх.- Алдааны мэдээллийг боловсруулж, Монгол хэлээр хэрэглэгчид харуулдаг байх.

6	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага	<ul style="list-style-type: none"> - Системийн туршилтын шатанд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэж, дүгнэлт зөвлөмжийг тусгасан байх. - Программ хангамжийн шинэчлэгдсэн, хамгийн сүүлийн, тогтвортой хувилбаруудыг ашиглах.
7	Платформ болон үйлдлийн систем	<ul style="list-style-type: none"> - Виртуал технологи, docker, Kubernetes гэх мэт контейнер технологи дэмждэг байх. - Хэрэглэгчийн төхөөрөмжийн сонголтоос үл хамааран дэмжин ажиллах “cross- platform independent” байдлаар хөгжүүлсэн байна.

6. ПРОГРАММ ХАНГАМЖ ХӨГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА

- Цахим системийг хөгжүүлэхдээ түгээмэл ашиглагддаг веб систем хөгжүүлэх програмчлалын технологи ашиглах;
- Гүйцэтгэгч нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд байх;
- Гүйцэтгэгч нь **ISO27001:2022** буюу **MNS ISO27001:2023/** Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг байгууллагын бүхий л үйл ажиллагааны түвшинд бүрэн хэрэгжүүлж, “**ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ**”-с итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулсан байх;
- Гүйцэтгэгч нь мэдээлэл технологийн үйл ажиллагаа эрхлэгч байх бөгөөд салбартаа танигдсан, санхүүгийн салбарт програм хийж байсан 2-с доошгүй жилийн туршлагатай байх;
- Программ хангамжийн өгөгдлийн сан **MySQL, PostgreSQL** буюу түүнтэй дүйцэхүйц түгээмэл ашиглагддаг өгөгдлийн сангийн технологи ашиглах. **Sql** болон **Nosql** хосолсон шийдэл ашиглах;
- Програмчлалын эх кодыг **Java – 20 version, NextJS –14 version** -с хойш хамгийн сүүлийн үеийн хувилбар ашиглаж хөгжүүлэх;
- Програмчлалын чанар стандарт дээр **Sonarqube** стандарт ашиглах;
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн **Application Development Framework** ашиглах;
- Систем дээр **microservice**-ээр тохируулах хоорондын холболтыг **GRPC** ашиглан холбох;
- Системийг бодит орчинд бэлтгэсэн серверт байршуулахдаа **docker** программыг ашиглах;
- Веб технологид суурилсан байна. Түгээмэл хэрэглэгддэг бүх төрлийн веб хөтөч дээр хэвийн ажилдаг байх;
- Программ хангамжийн бүтээгдэхүүний оюуны өмчийн эрхийг “Санхүүгийн зохицуулах хороо” эзэмших бөгөөд гүйцэтгэгч тал дахин ашиглах, ижил төстэй төрлийн үйл ажиллагаанд СЗХ-с бусад байгууллагад дахин ашиглахгүй байна;
- Программын эх код, өгөгдлийн урсгалын диаграм, классын диаграм, **UML**, кодын тайлбар, программд өөрчлөлт оруулах нэмж хөгжүүлэхэд шаардлагатай гарын авлага зааваруудыг Санхүүгийн зохицуулах хорооны цаасан болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө;
- Программ хангамжийг хүлээлгэн өгснөөс хойш 1 жилийн хугацаанд программ хангамжийн энэхүү ажлын шаардлагын дагуу хөгжүүлэгдсэн системийн алдаа засварыг үнэ төлбөргүй хийх;

7. СҮЛЖЭЭ БА ХОЛБОЛТЫН ШААРДЛАГА

- Вэб сервер, файл сервер, өгөгдлийн сервер зэрэг төрлүүдтэй, хэрэглэгч мэдээлэл оруулах авахад хялбар, хурдтай байхаар зохицуулагдсан байна;
- Монгол улсын интернетийн холболт удаан алслагдсан сум сууринаас холбогдон ажиллах мэдээлэл дамжуулах, авах хялбаршуулсан хувилбартай байна;
- Дотоод болон гадаад сүлжээний орчинд ажиллах боломжтой байх;

8. ПРОГРАММ ХАНГАМЖИД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- Хүнд ойлгомжтой, энгийн, дизайны орчин үеийн чиг хандлагад нийцсэн байх;
- Хэрэглэгчийн эрхийн олон түвшинтэй уян хатан ангилалтай байх;
- Хэрэглэгчийн түвшинд ижил дизайнтай байх;
- Сүлжээний бага хурдад ажиллах хөнгөн байх;
- Динамик бүтэцтэй байх;
- Өмчийн мэдээлэлд хиймэл оюун ухаанаар аналитик тайлан хийж мэдээлдэг байх;
- Программ хангамжаас гарах бүх төрлийн тайланг MS Excel, MS Word, PDF болон шаардлагатай форматаар гаргах боломжтой байх;
- Санхүүгийн программ, Төрийн бусад байгууллага, ХУР системээс мэдээлэл авах, мэдээлэл дамжуулах боломжтой байх;
- Он оноор мэдээллийн архив үүсгэдэг байх, архиваас мэдээлэл харахад хялбар байх;

9. ПРОГРАМ ХАНГАМЖИЙН БАРИМТЖУУЛАЛТ

- Системийн анализ ба дизайн хүлээлгэн өгөх;
 - Системийн архитектур;
 - Ерөнхий зураглал;
 - Нарийвчилсан зураглал;
- “USE CASE” диаграм хүлээлгэн өгөх;
- “Mockup” зураглал батлуулах;
- “Activity” диаграм хүлээлгэн өгөх;
- “Sequence” диаграм хүлээлгэн өгөх;
- Өгөгдлийн сангийн бүтцийн диаграм баримтжуулан хүлээлгэн өгөх;
- Хүснэгт, хүснэгтийн талбарын тайлбарыг баримтжуулан хүлээлгэн өгөх;
- Хэрэглэгчийн шаардлагын өөрчлөлт баримтжуулан хүлээлгэн өгөх;
- Программын эх кодын тайлбарыг хүлээлгэн өгөх;
- Тестийн үр дүнг баримтжуулан хүлээлгэн өгөх;
- Программын гарын авлага хүлээлгэн өгөх;
- Систем суурилуулалтын гарын авлага хүлээлгэн өгөх;
- Асуудал шийдвэрлэх гарын авлага хүлээлгэн өгөх;
- Программ хангамж хүлээлцсэн акт хүлээлгэн өгөх;
- Системийг суурилуулан хэвийн ажиллах хамгийн бага техник хангамжийн үзүүлэлтийг баримтжуулан хүлээлгэн өгөх;
- Программын “Prototype” -ийг баталгаажуулан хүлээлгэн өгөх;
- Төслийн багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь баталгаажуулан хүлээлгэн өгөх;
- “Entity Relationship” диаграм баталгаажуулан хүлээлгэн өгөх;
- “User interface программын дизайн баталгаажуулан хүлээлгэн өгөх;

10. СУРГАЛТЫН ШААРДЛАГА

- Функциональ түвшний хэрэглэгчийн сургалт зохион байгуулах;
- Программ хангамжийг ашиглах цахим гарын авлага
- Системийн инженерүүдэд сургалт зохион байгуулах;
- Программ хангамжийн инженерүүдэд программын кодын сургалт зохион байгуулах;
- Системийн удирдагчдад системийн удирдлагын, тайлангийн загварчлалын сургалт зохион байгуулах;
- Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох 2-аас доошгүй мэргэжилтнийг тухайн программыг хөгжүүлсэн программын хэл, application framework-ийн сургалтад хамруулсан байх;
- Санхүүгийн зохицуулах хороонд сургалт зохион байгуулах;